

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaa.e@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ТАЙШИР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.УНДРАХ ТАНАА

2025. 02. 24 № 88

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар букуу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Эрдэнэ бишрэлт хошууны түүх, соёл, байгалийн эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагааны зардал, улс, аймгийн аварга малчин, хөдөлмөрийн аварга, оны шилдгүүдийн шагнал, тэмээчдийн баяр, Улаанбаатар хотод нутгийн сар шинийн золголт зохион байгуулах арга хэмжээ,

8225920223

- Засаг даргын үйл ажиллагааны тайланг иргэдэд танилцуулах арга хэмжээний шатахуун, авто машины засварт нийт 31,735.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Тамгын даргад 3,162.3 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон, 263.2 мянган төгрөгийн шатахуун, 1,218.0 мянган төгрөгийн албан томилолтын анхан шатны баримт олгосон
 - Монсульт ХХК-д шатахууны үнэ 9,860.0 мянган төгрөгийн шатахууны мөнгө шилжүүлэн, сумын зам тохижилт засварын ажил зарцуулсан түлшний зарцуулалтын анхан шатны баримтгүй хангалтгүй,
 - Тоног төхөөрөмж худалдан авахаар 7,742.0 мянган төгрөгийн шилжүүлсэн ч хөрөнгө ирээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос 51,752.4 мянган төгрөгийг сургууль, цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ, халуун усны засварт, 47,841.0 мянган төгрөгийг сумын тохижилт, гэрэлтүүлэг, самбар хийхэд зарцуулжээ.

Иргэд, байгууллагаас 258,742.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 142,355.5 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 785,114.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс 32,181.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 42 арга хэмжээг бүрэн, 9 арга хэмжээг 70.0 хувь, 3 арга хэмжээг 30.0 хувьтай хэрэгжүүлэн нийт дүнгээр 80.4 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	209,870,291.96	244,190,548.01
33	АВЛАГА	38,877,400.00	70,674,656.05
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	29,794,476.05
335	Бусад авлага	38,877,400.00	40,880,180.00
33510	Байгууллагаас авах авлага	38,877,400.00	21,614,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	19,266,180.00
35	БАРАА МАТЕРИАЛ	170,992,891.96	173,515,891.96
354	Хангамжийн материал	39,387,891.96	41,910,891.96
35410	Бичиг хэргийн материал	780,139.00	780,139.00
35420	Аж ахуйн материал	17,854,949.96	20,377,949.96
35470	Бусад хангамжийн материал	20,752,803.00	20,752,803.00
35600	Мал амьтад	131,605,000.00	131,605,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,316,211,272.08	1,594,992,019.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,316,211,272.08	1,594,992,019.20
392	Биет хөрөнгө	1,262,257,065.80	1,541,833,103.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,417,044,609.25	1,575,555,710.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(575,796,594.62)	(702,804,349.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,923,160.00	267,923,160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,192,687.66)	(71,439,826.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	138,257,255.00	140,941,955.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,486,311.89)	(105,474,996.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,777,496.77	43,277,496.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,212,624.96)	(32,747,447.98)
39209	Зам, гүүрийн байгууламж	333,685,380.00	352,801,380.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(219,758,872.62)	(224,198,589.30)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	9,720,000.00	9,720,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	316,967,000.01	446,574,363.01
39215	Хуримтлагдсан элэгдэл	(110,448,773.48)	(159,073,782.71)
39217	Ном	778,030.00	778,030.00
393	Биет бус хөрөнгө	53,954,206.28	53,158,916.18
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,110,833.64)	(1,285,833.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	56,006,200.00	56,006,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,481,160.08)	(3,101,450.10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,526,081,564.04	1,839,182,567.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,904,947.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,904,947.10
413	Өглөг	-	1,830,287.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,074,660.00
4136	Бусад өглөг	-	1,074,660.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,074,660.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,526,081,564.04	1,836,277,620.11
51	Засгийн газрын хувь оролцоо	1,526,081,564.04	1,836,277,620.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	517,078,580.53	517,078,580.53
51101	Өмч: - төрийн	517,078,580.53	517,078,580.53
512	Хуримтлагдсан үр дүн	737,417,096.67	1,047,613,152.74
51210	Өмнөх үеийн үр дүн	737417096,67	736,539,696.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	311,073,456.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,585,886.84	271,585,886.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,526,081,564.04	1,839,182,567.21

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	759,745,094.00	1,336,678,725.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	131,046,985.00	432,425,763.00
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	550,000.00	1,210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000.00	1,210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	114,569,752.00	429,832,763.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,927,233.00	1,383,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,698,109.00	904,252,962.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,294,209.00	151,319,662.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,734,209.00	148,974,662.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,500,000.00
131105	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.00	845,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,403,900.00	752,933,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,403,900.00	752,933,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	778,024,313.08	1,025,605,268.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,024,313.08	1,025,605,268.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	744,223,069.41	979,683,990.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,866,664.00	450,191,390.82
210101	Үндсэн цалин	191,216,742.34	207,012,333.05
210102	Нэмэгдэл	69,509,136.66	235,466,807.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,428,000.00	-
210104	Урамшуулал	20,712,785.00	7,712,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,008,139.88	58,133,451.68
210201	Тэтгэврийн даатгал	26,269,390.95	40,565,452.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,812,199.60	4,504,144.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,349.33	2,252,072.37
210204	Ажилгүйдлийн даатгал	460,300.00	2,158,484.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,602,900.00	8,653,297.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,558,973.75	50,849,465.72
210301	Гэрэл, цахилгаан	5,040,473.75	7,321,090.72
210302	Түлш, халаалт	38,518,500.00	43,528,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,239,515.40	45,981,974.92
210401	Бичиг хэрэг	3,185,200.00	3,420,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,689,234.00	36,363,909.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,637,619.40	3,877,364.12
210404	Ном, хэвлэл	165,750.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,701.80	70,701.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,982,880.00	2,250,000.00
210408	Бараа материал акталсны зардал	508,130.20	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,941,800.00	16,440,700.00
210604	Урсгал засвар	1,941,800.00	16,440,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,252,000.00	4,098,000.00
210702	Дотоод албан томилолт	5,252,000.00	4,098,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,167,873.50	5,145,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,104,161.50	3,690,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	604,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,580.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	143,088.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,540,000.00	590,000.00
210807	Газрын төлбөр	110,132.00	117,232.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,188,102.88	348,843,887.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,831,309.00	137,705,471.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	165,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,191,793.88	210,638,416.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,801,243.67	45,921,277.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	45,918,080.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		28,993,868.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,316,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	608,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилт	31,801,243.67	3,197.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,801,243.67	3,197.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,279,219.08)	311,073,456.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(18,279,219.08)	311,073,456.07

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	629,248,109.0	943,462,962.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	550,000.0	1,210,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	550,000.0	1,210,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	550,000.0	1,210,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000.0	1,210,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,698,109.0	942,252,962.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,294,209.0	189,319,662.0
131104	Дээд шатны ТЗ-ийн төсөвт тусгагдсан төсвөөс хуваарилсан хөрөнгө	65,734,209.00	186,974,662.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,500,000.00
131105	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.0	845,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,403,900.0	752,933,300.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,403,900.0	752,933,300.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	614,723,109.0	883,876,561.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,044,465.3	806,968,807.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	282,815,984.0	469,457,570.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,166,062.3	226,278,513.1
210101	Үндсэн цалин	69,509,136.7	235,466,807.8
210102	Нэмэгдэл	2,428,000.0	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,712,785.0	7,712,250.0
210104	Урамшуулал	35,008,139.9	56,303,164.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,269,391.0	38,735,165.3
210201	Тэтгэврийн даатгал	1,812,199.6	4,504,144.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,863,349.3	2,252,072.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	460,300.0	2,158,484.5
210204	Ажилгүйдлийн даатгал	4,602,900.0	8,653,297.8
210205	Эрүүл мэндийн даатгал	43,558,973.8	50,849,465.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,040,473.8	7,321,090.7
210301	Гэрэл, цахилгаан	38,518,500.0	43,528,375.0
210302	Түлш, халаалт	32,359,210.2	41,228,314.9
2104	Хангамж, бараа материалын зардал	3,280,200.0	4,000,000.0
210401	Бичиг хэрэг	23,704,209.0	31,886,249.0
210402	Тээвэр, шатахуун	2,842,219.4	3,877,364.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	165,750.0	-
210404	Ном, хэвлэл	70,701.8	70,701.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,296,130.0	1,394,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,000.0	-
2105	Нормативт зардал	9,298,500.0	20,939,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.0	3,872,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,698,500.0	17,067,700.0
210604	Урсгал засвар	5,252,000.0	4,098,000.0
2107	Томилолт, зочны зардал	5,252,000.0	4,098,000.0
210702	Дотоод албан томилолт	24,817,373.5	5,145,120.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,753,661.5	3,690,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.0	604,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	147,580.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,000.0	143,088.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,540,000.0	590,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	110,132.0	117,232.0
210807	Газрын төлбөр	108,864,284.0	158,947,471.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,699,284.0	158,447,471.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,000.0	500,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,678,643.7	76,907,754.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.0	47,110,080.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	28,993,868.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,316,212.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,000,000.0	1,800,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,678,643.7	29,797,674.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилт	31,801,243.7	3,198.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,877,400.0	29,794,476.1
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,525,000.0	59,586,401.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,525,000.0	59,586,401.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,525,000.0	59,586,401.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,525,000.0	59,586,401.0
2200	Дотоод эх үүсвэрээр	14,525,000.0	59,586,401.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,525,000.0	59,586,401.0
6	хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,525,000.0)	(59,586,401.0)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023.01.01-ний үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	755,696,315.75	1,544,360,783.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	755,696,315.75	1,544,360,783.12
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,279,219.08)	(18,279,219.08)
C08	2023.12.31-ний үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	737,417,096.67	1,526,081,564.04
D01	2024.01.01-ний үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	737,417,096.67	1,526,081,564.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-877,400.00	-877,400.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	736,539,696.67	1,526,081,564.04
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	311,073,456.07	311,073,456.07
D09	2024.12.31-ний үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	1,047,613,152.74	1,836,277,620.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	785,614,300.00	754,140,102.04	31,474,197.96	95.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	785,614,300.00	754,140,102.04	31,474,197.96	95.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735,472,300.00	707,030,022.04	28,442,277.96	96.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,876,100.00	469,457,570.82	3,418,529.18	99.28
210101	Үндсэн цалин	140,000,000.00	226,278,513.05	-86,278,513.05	161.63
210102	Нэмэгдэл	332,876,100.00	235,466,807.77	97,409,292.23	70.74
210104	Урамшуулал	-	7,712,250.00	-7,712,250.00	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,109,500.00	56,303,164.58	2,806,335.42	95.25
210201	Тэтгэврийн даатгал	40,194,400.00	38,735,165.25	1,459,234.75	96.37
210202	Тэтгэмжийн даатгал	4,728,800.00	4,504,144.74	224,655.26	95.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,364,400.00	2,252,072.37	112,327.63	95.25
210204	Ажилгүйдлийн даатгал	2,364,400.00	2,158,484.45	205,915.55	91.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,457,500.00	8,653,297.77	804,202.23	91.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,578,900.00	50,849,465.72	2,729,434.28	94.91
210301	Гэрэл, цахилгаан	7,327,500.00	7,321,090.72	6,409.28	99.91
210302	Түлш, халаалт	46,251,400.00	43,528,375.00	2,723,025.00	94.11
2104	Хангамж, бараа материалын зардал	35,494,000.00	35,342,065.92	151,934.08	99.57
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	26,000,000.00	26,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,877,364.12	122,635.88	96.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	70,701.80	29,298.20	70.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн ЭЗ	1,394,000.00	1,394,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,777,100.00	22,844,500.00	1,932,600.00	92.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,777,100.00	5,776,800.00	300.00	99.99
210604	Урсгал засвар	19,000,000.00	17,067,700.00	1,932,300.00	89.83
2107	Томиллолт, зочны зардал	5,708,800.00	4,098,000.00	1,610,800.00	71.78
210702	Дотоод албан томиллолт	5,708,800.00	4,098,000.00	1,610,800.00	71.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,851,000.00	1,455,120.00	395,880.00	78.61
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	604,800.00	45,200.00	93.05
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	-	177,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	149,000.00	143,088.00	5,912.00	96.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	590,000.00	130,000.00	81.94
210807	Газрын төлбөр	155,000.00	117,232.00	37,768.00	75.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,076,900.00	66,680,135.00	15,396,765.00	81.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,576,900.00	66,180,135.00	15,396,765.00	81.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,142,000.00	47,110,080.00	3,031,920.00	93.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,142,000.00	47,110,080.00	3,031,920.00	93.95
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж	32,022,000.00	28,993,868.00	3,028,132.00	90.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,320,000.00	16,316,212.00	3,788.00	99.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	785,614,300.00	754,140,102.04	31,474,197.96	95.99
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	785,114,300.00	752,930,102.04	32,184,197.96	95.90
132001	Орон нутгийн төсвөөс	785,114,300.00	752,930,102.04	32,184,197.96	95.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	1,210,000.00	-710,000.00	242.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	500,000.00	1,210,000.00	-710,000.00	242.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	19	6	-
620001	Удирдах ажилтан	6	6	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	12	8	4	-
620003	Үйлчлэх ажилтан	3	2	1	-
620004	Гэрээт ажилтан	4	3	1	-

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	66,294,209.00	189,319,662.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,294,209.00	189,319,662.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,416,809.00	159,525,185.95
2104	Хангамж, бараа материалын зардал	984,209.00	5,886,249.00
210401	Бичиг хэрэг	280,000.00	
210402	Тээвэр, шатахуун	704,209.00	5,886,249.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,952,600.00	3,690,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,952,600.00	3,690,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,480,000.00	149,948,936.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,480,000.00	149,948,936.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,877,400.00	29,794,476.05
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,877,400.00	29,794,476.05
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,877,400.00	29,794,476.05
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	66,294,209.00	189,319,662.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,294,209.00	189,319,662.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,734,209.00	188,474,662.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.00	845,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 135,567.2 мянган төгрөгийн 9 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

• **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Агнуур судлалын нийгэмлэгтэй сумын Засаг дарга "Говь-алтай аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт хийх судалгааны ажлын дэд гэрээ"-г 2024.09.06-ны өдөр 2024/02 байгуулан 10,000.0 мянган төгрөгийг төлж аймгийн ан агнуурын менежментийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн хүлээлгэн өгөөгүй байхад авлагаар бүртгээгүй;
- НАСАН-ИТГЭЛТ ХХК-аас худалдан авсан 1,904.8 мянган төгрөгийн үнэ бүхий Tablet -ийг хөрөнгөд орлого аваагүй;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан ажилтны нөхөн төлбөрт төсвөөс 17435.8 мянган төгрөгийн цалин, НДХ-т 1,830.3 мянган төгрөгийг НДШ-т төлж Говь-Алтай аймаг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

- 2024.05.17-ны өдрийн дугаар 112/ШШ2024/0019 захирамжийн дагуу хариуцагч сумын Засаг даргаас авах авлагыг тайланд тусгаагүй;
- ШШГА-ны шийдвэрийн дагуу нөхөн төлсөн шимтгэлийн 1,830.3 мянган төгрөгийг тайланг өгч нөхөн тооцоо хийгээгүй, байгууллагын 2024 оны төлсөн шимтгэлийн тооцоонд оруулан тооцоо нийлснээс дээрх дүнгээр тайланд өглөгийг тусгаагүй;
 - ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 25,794.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй;
 - Сумын 100 жилийн ойн дэмжлэгийн зардлаас Халуун усны газарт 10,111.1 мянган төгрөг зарцуулсныг хөрөнгийн сайжруулалтаар бүртгээгүй мөн худалдан авсан гэрэлтүүлгийн 4,000.0 мянган төгрөг, төмөр самбарын 1,320.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого аваагүй, 1,140.0 мянган төгрөгийн худалдан авсан хулдаасыг аж ахуйн материалд орлого авч бүртгээгүй;
 - Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 17,336.4 мянган төгрөгөөр худалдан авсан болон хандивын хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан, үнэ төлбөргүй орлогыг үр дүнгийн тайланд 31,250.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
 - Нутгийн төгөл ХХК-д мод, суулгацын үнэнд 7,742.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж тайланд авлагаар тусгаагүй;
 - Алтайн ган дүүрэн ХХК-аас компьютер принтер худалдан авахаар 3872.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Аудитаар нийт 87,394.3 мянган төгрөгийн 14 зөрчил² илэрч 12,867.6 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 53,430.3 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгуулах албан шаардлага, цаашид зөрчлийг давтан гаргуулахгүй байх 21,096.4 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ. /Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн зөрчил нь албан шаардлагын дүнд орсон болно/

3.2 Төлбөрийн акт

1. Шатахууны зардлыг түүвэрлэн шалгахад Монсульт ХХК-д шатахууны үнийг 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдөр шилжүүлэхдээ зөвшөөрлийн бичиггүй 111.2 мянган төгрөгийг төлсөн, мөн 03 дугаар сарын 06-ны өдөр төлбөрийг шилжүүлэхдээ 152.0 мянган төгрөгийг нэхэмжлэх дээр нэмж засаж бичсэн дүнгээр шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй илүү төлсөн шатахууны 263.2 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 21/102 тоот албан бичгийг үндэслэн сумын Засаг даргын захирамжгүй ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ц.Одмандахад 4 дүгээр сараас эхлэн гамшгаас хамгаалах нэмэгдлийг үндсэн цалингаас 40 хувиар тооцон нийт 3,162.3 мянган төгрөгийн цалинг бодож олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захирамж шийдвэр гараагүй байхад илүү олгосон цалингийн 3,162.3 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын төсвөөс Улаанбаатар хотод нутгийн золголтод оролцсон 7 ажилтанд 1218.0 мянган төгрөгийн албан томилолтоор ажилласан зардлыг олгосон ч анхан шатны баримтгүй, гүйцэтгэсэн ажлын удирдамж, хянасан албан тушаалтны шийдвэр байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй олгосон албан томилолтын 1,218.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

4. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1 ажилтанд 482.1 мянган төгрөгөөр илүү олгосон байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон 482.1 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас гэрээ байгуулаагүй, мод, суулгацаа аваагүй байхад Нутгийн төгөл ХХК-д 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдөр 7,742.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, нягтлан бодогч тайланд зардлаар бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй урьдчилж олгосон мод суулгацын үнэ 7,742.0 мянган төгрөгийг Нутгийн төгөл ХХК-аар төлүүлж; орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.3 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс Эрдэнэ бишрэлт хошууны түүх, соёл, байгалийн эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагааны зардалд 8,000.0 мянган төгрөг, улс, аймгийн аварга малчин, хөдөлмөрийн аваргын шагналд 5,520.0 мянган төгрөг, ахмадын холбоо, ахмадуудад 1,780.0 мянган төгрөг, Улаанбаатар хотод нутгийн сар шинийн золгуудыг зохион байгуулах арга хэмжээнд 9,935.0 мянган төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны

тайланг иргэдэд танилцуулах шатахууны зардалд 3,150.0 мянган төгрөг, сумын онцлох шилдэгүүдийн шагналд 3,850.0 мянган төгрөг, авто машины засварт 2,000.0 мянган төгрөг, эр цэргийн баярын шагналд 800.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгаж, цаашид хөрөнгийг хууль, журмыг зөрчин зарцуулдаг байдлыг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Нэмэлт санхүүжилтийн данснаас 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монсуль ХХК-д 9,860.0 мянган төгрөгийг шатахууны үнэ шилжүүлснийг тайланд орлого аваагүй, нягтлан бодогч шууд зардлаар бүртгэсэн ба нэмэлт тайлбараар сумын төвийн ганганы замыг засаж өргөсгөн шороо тэгшлэх мөн гүүрний орчим хэсгийн газрыг засварлах, нүхэн жорлонг буулгаж ажилд цэргийн ангийн техник автомашинд түлш өгч ажлыг гүйцэтгэх боловч анхан шатны баримтгүй, зарцуулалтын тайлан гаргаагүй нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг хууль, журмыг зөрчин анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгадаг байдлыг таслан зогсоож, шатахууны зарцуулалт, ажлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу гарган дахин хянаж, хэлэлцэн, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллага жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээд тооллогоор дутагдсан 688.5 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй орхисон, худалдан авсан хөрөнгө орлого аваагүй байхад тооллогоор илрээгүй, оны эцэст хөрөнгөд гарсан өөрчлөлтийн талаар тайланд тайлбар хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн "Эд хөрөнгийн тооллого явуулах журам" 73.2.2. Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй, тооцоо бодоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

4. Нягтлан бодогч шатахууны тайлангийн орлогыг авахдаа зарим гүйлгээг шилжүүлсэн бөөн дүнгээр орлого авч нэгжийн үнээр аваагүй, жолоочийн замын хуудсыг нэгтгэн сар бүр тооцоо бодсон акт үйлдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцоог сар бүр бодоогүй, түүнд хяналт тавьж ажиллахгүй байгаа зөрчлийг арилгаж, цаашид удирдлагаас шатахууны зарцуулалтын тайланд тавих хяналтыг сайжруулан, ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5. Байгууллага нь төсвийн хөрөнгөөр 5,776.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн орлогоос тайлант онд самбар, хулдаасан хэвлэлийн үнэнд 5,370.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх бүхий албан тушаалтны хууль, журмын дагуу гаргасан шийдвэрийн дагуу өмнөх оны төвлөрүүлсэн орлогыг зарцуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд нягтлан бодогч санхүүгийн тайланд өглөг, авлагыг зөрүүтэй тусгасан, хөрөнгийг бөөн дүнгээр орлого авсан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг гаргаагүйгүй автомашинд сэлбэг худалдан авч зарцуулсан, ойн арга хэмжээ угтан хийгдсэн урсгал засвар, шатахууны зарцуулалтын ажлын үр дүнг хэлэлцэж, ойн комисс хүлээн авсан шийдвэр байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8

дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-т "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахдаа эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх

Өгсөн зөвлөмж: Удирдлагаас нягтлан бодох бүртгэл хөтөлөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулж, ойн арга хэмжээний хүрээнд хийгдсэн урсгал засварын ажлын дүнг сумын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд байнгын хяналтаа хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Илрүүлэлт:

Тайшир сумын Засаг даргын захирамжаар сумын ЗДТГ-ын даргыг Говь-Алтай аймаг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 05 дугаар 17-ны өдрийн дугаар 112/ШШ2024/0019 захирамжаар ажлаас чөлөөлөгдсөний нөхөн төлбөрийг байгууллагаас төлж, буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэсний дагуу байгууллагын төсвөөс 17,435.8 мянган төгрөгийн цалинг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, нийгмийн даатгалын шимтгэлийн 1,830.3 мянган төгрөгийг аймгийн НДХ-т төлсөн байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас төрд учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан 21,096.4 мянган төгрөгийн хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	Агнуур судлалын нийгэмлэгтэй сумын Засаг дарга "Говь-алтай аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт хийх судалгааны ажлын дэд гэрээ"-г байгуулан 10,000.0 мянган төгрөгийг төлж төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн хүлээлгэн өгөөгүй байхад авлагаар бүртгээгүй.	1	10,000.0	1	10,000.0			1	10,000.0	-	-	-	-
	НАСАН-ИТГЭЛТ ХХК-аас худалдан авсан 1,904.8 мянган төгрөгийн үнэ бүхий Tablet -ийг хөрөнгөд орлого аваагүй.	1	1,904.8	1	1,904.8			1	1,904.8	-	-	-	-
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан ажилтны нөхөн төлбөрт төсвөөс 17435.8 мянган төгрөгийн цалин, НДХ-т 1,830.3 мянган төгрөгийг НДШ-т төлж Говь-Алтай аймаг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.05.17-ны өдрийн дугаар 112/ШШ2024/0019 захирамжийн дагуу хариуцагч болох сумын Засаг даргаар ажиллаж байсан иргэнээс авах авлагыг тайланд тусгаагүй байна.	1	19,266.1	1	19,266.1			1	19,266.1				
	ШШГА-ны шийдвэрийн дагуу нөхөн төлсөн шимтгэлийн 1,830.3 мянган төгрөгийг тайланг өгч тооцоо хийгээгүй, байгууллагын 2024 оны төлсөн шимтгэлийн тооцоонд оруулан тооцоо нийлснээс тайланд өглөгийг тусгаагүй байна.	1	1,830.3	1	1,830.3			1	1,830.3				
	ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 25,794.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн	1	25,794.5	1	25,794.5			1	25,794.5				

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

	санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.												
	Сумын 100 жилийн ойн дэмжлэгийн зардлаас Халуун усны газарт 10,111.1 мянган төгрөг зарцуулсныг хөрөнгийн сайжруулалтаар бүртгээгүй мөн худалдан авсан гэрэлтүүлгийн 4,000.0 мянган төгрөг, төмөр самбарын 1,320.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого аваагүй, 1,140.0 мянган төгрөгийн худалдан авсан хулдаасыг аж ахуйн материалд орлого авч бүртгээгүй байна.	1	16571.1	1	16571.1			1	16571.1				
	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 17,336.4 мянган төгрөгөөр худалдан авсан болон хандивын хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан, үнэ төлбөргүй орлогыг үр дүнгийн тайланд 31,250.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	48,586.4	1	48,586.4			1	48,586.4				
	Нутгийн төгөл ХХК-д мод, суулгацын үнэнд 7,742.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж тайланд авлагаар тусгаагүй.	1	7,742.0	1	7,742.0			1	7,742.0				
	Алтайн ган дүүрэн ХХК-аас компьютер принтер худалдан авахаар 3872.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж тайланд авлагаар тусгаагүй байна.	1	3872.0	1	3872.0			1	3872.0	-	-	-	-
Дүн		9	135,567.2	9	135,567.2			9	135,567.2		-	-	-

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	Монсульт ХХК-д шатахууны үнийг 2024.02.07-нд шилжүүлэхдээ зөвшөөрлийн бичиггүй 111.2 мянган төгрөгийг төлсөн, 2024.03.06-ны өдөр 152.0 мянган төгрөгийг нэхэмжлэх дээр нэмж засаж бичсэн дүнгээр шилжүүлсэн.	1	263.2	1	263.2					-	-	-	
	Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын 2024.04.22-ны өдрийн 21/102 тоот албан бичгийг үндэслэн сумын Засаг даргын захирамжгүй ЗДТГ-ын дарга Ц.Одмандахад 4 дүгээр сараас гамшгаас хамгаалах нэмэгдлийг үндсэн цалингаас 40 хувиар тооцон нийт 3,162.3 мянган төгрөгийн цалинг бодож олгосон байна.	1	3,162.3	1	3,162.3					-	-	-	
	Байгууллагын төсвөөс Нутгийн золголт арга хэмжээнд оролцсон 7 ажилтанд 2024.03.13-ны өдөр 1218.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон ч анхан шатны баримтгүй, гүйцэтгэсэн ажлын удирдамж, хянасан албан тушаалтны шийдвэр байхгүй байна.	1	1,218.0	1	1,218.0					-	-	-	
	Цалингийн зардлаас 1 ажилтанд амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 482.1 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	482.1	1	482.1					-	-	-	
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас гэрээ байгуулаагүй, мод, суулгацаа аваагүй байхад Нутгийн төгөл ХХК-д 2024.12.24-ны өдөр 7,742.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, нягтлан бодогч тайланд зардлаар бүртгэсэн байна.	1	7,742.0	1	7,742.0					-	-	-	
	ЗДНХ-с Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагааны зардалд 8,000.0 мянга, улс, аймгийн аварга малчин, хөдөлмөрийн аваргын шагналд 5,520.0 мянга, ахмадын холбоо, ахмадуудад 1,780.0 мянга, Улаанбаатар хотод нутгийн сар шинийн золголт зохион байгуулах арга хэмжээнд	1	31,735.0				1	31,735.0			-	-	-

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	Улаанбаатар хотод нутгийн сар шинийн золголт зохион байгуулах арга хэмжээнд 9,935.0 мянга, Засаг даргын үйл ажиллагааны тайланг иргэдэд танилцуулах шатахууны зардалд 3,150.0 мянга, сумын шилдгийн шагналд 3,850.0 мянга, авто машины засварт 2,000.0 мянга, эр цэргийн баярын шагналд 800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.										
	Нэмэлт санхүүжилтийн данснаас 2024.06.07-ны өдөр Монсульт ХХК-д 9,860.0 мянган төгрөгийг шатахууны үнэнд шилжүүлснийг тайланд орлого аваагүй, нягтлан бодогч шууд зардлаар бүртгэсэн, анхан шатны баримтгүй ба зарцуулалтын талаар нэмэлт тайлбар авахад ТГ-ын дарга сумын төвийн ганганы замыг засаж өргөсгөн шороо тэгшлэх мөн гүүрний орчим хэсгийн газрыг засварлах, нүхэн жорлонг буулгаж ажилд цэргийн ангийн техник автомашинд түлш өгч ажлыг гүйцэтгэсэн байна.	1	9,860.0			1	9,860.0			-	-
	Байгууллага жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээд тооллогоор дутагдсан 688.5 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй орхисон, худалдан авсан хөрөнгө орлого аваагүй байхад тооллогоор илрээгүй, оны эцэст хөрөнгөд гарсан өөрчлөлтийн талаар тайланд тайлбар хийгээгүй байна.	1	688.5			1	688.5				
	Шатахууны тайланг нягтлан бодогч орлогыг авахдаа шилжүүлсэн бөөн дүнгээр орлого авч нэгжийн үнээр аваагүй, жолоочийн замын хуудсыг нэгтгэн сар бүр тооцоо бодсон акт үйлдээгүй байна.	1	-			1	-			-	-
	Тайлант онд нягтлан бодогч санхүүгийн тайланд өглөг, авлагыг зөрүүтэй тусгасан, хөрөнгийг бөөн дүнгээр орлого авсан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг гаргаагүй автомашинд сэлбэг худалдан авч зарцуулсан, ойн арга хэмжээ угтан хийгдсэн урсгал засвар, шатахууны зарцуулалтын ажлын үр дүнг хэлэлцэж, ойн комисс хүлээн авсан шийдвэр байхгүй байна.	1						1			

Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	Тайшир сумын Засаг даргын захирамжаар сумын ЗДТГ-ын дарга П.Ундрах ажлаас чөлөөлөгдсөн ба Говь-Алтай аймаг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.05.17-ны өдрийн дугаар 112/ШШ2024/0019 захирамжаар ажлаас чөлөөлөгдсөний нөхөн төлбөрийг байгууллагаас төлж, буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэсний дагуу байгууллагын төсвөөс 17435.8 мянган төгрөгийн цалинг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, нийгмийн даатгалын шимтгэлийн 1,830.3 мянган төгрөгийг аймгийн НДХ-т төлсөн байна.	1	21,096.4					1	21,096.4		
	Байгууллага нь төсвийн хөрөнгөөр 5,776.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	5,776.8			1	5,776.8		-	-	-
	Нэмэлт санхүүжилтийн данснаас самбар болон хулдаасан хэвлэл хийхэд нийт 5,370.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	5,370.0			1	5,370.0				
Нийт		13	87,394.3	5	12,867.6	6	53,430.3	2	21,096.4	-	-

/мянган төгрөгөөр/

4.3 Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Тайшир сумын Засаг даргын Тамгын газар	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 366,135.4 мянган төгрөгийн 25, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 198,599.8 мянган төгрөгийн 21, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 74,409.7 мянган төгрөгийн 13 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
дүн		1	-			1	-				-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
		2	3	4	5	7	8	9	10
А	1								
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		